БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМНЫ ХАРЬЯА

**БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө 10, Багшийн хөгжлийн ордон,
Утас, факс: (976) 7014 0069, http://www.itpd.mn

2017.11.24 № 1/349

танай ____________-ны № ______________-т

КОЭЙ СУДАЛГАА
ШИНЖИЛГЭЭНИЙ ЗӨВЛӨХ
КОМПАНИЙН ЗАХИРАЛ
КООЯМА МАСАЮКИ

Талархал илэрхийлэх тухай

Таны энэ өдрийн амгаланг айлтгая

Монгол Улсын тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын Япон Улсад туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх сургалт 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 20-ны өдрийн хооронд Токио хотод амжилттай явагдаж дууслаа. Сургалтын үйл ажиллагааны хүрээнд Япон Улсын боловсролын тогтолцоо, тэгш хамруулан сургах боловсрол, тусгай дэмжлэгт сургууль цэцэрлэгийн багшийн арга зүй, сургалтын орчин, төгсөгчдийн ажлын байр зэрэг нөхцөл байдалтай танилцан туршлага судалж, олон шинэ санаа олж харсандаа бид баяртай байна.

Энэ сургалтаар биднийг хүлээн авч Япон Улсын боловсролын тогтолцоо, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, мэргэжлийн сургалттай ахлах сургууль, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, тэгш хамруулан сургаж буй сургалтын үйл ажиллагаа явуулж буй байгууллага бүртэй танилцуулсан танай хамт олонд талархаж байна. Танай байгууллагаас манай улсад хэрэгжүүлж буй тусгай хэрэгцээт боловсролын төсөл, япон багш нарын чин сэтгэлээсээ багш, хүүхдийн төлөө ажиллаж байгаа нь бидэнд онцгой сэтгэгдэл түрүүлснийг дурдахад таатай байна. Эдгээр үйл ажиллагааг өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх болно.

Монголын тусгай хэрэгцээт боловсролын байгууллагын багш нарыг мэргэжил арга зүйн хувьд чадваржуулахад дэмжлэг үзүүлсэн та бүхэнд гүн талархлаа илэрхийлж байгаагаа үүгээр уламжилж байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

ЗАХИРАЛ А.ТУЯА

2017 0455

2017年11月24日

(株)コーエイリサーチ&コンサルティング
代表取締役社長　神山雅之殿

拝啓　向寒の候、時下ますますご清祥の段、お慶び申し上げます。この度は格別のご厚誼にあずかり、厚く御礼申し上げます。

この度はお陰様を持ちまして、「モンゴル国教員研修所主催日本スタディーツアー」を成功裏に終えることができました。スタディーツアーを通して、日本の教育システムやインクルーシブ教育、特別支援学校や幼稚園教員の教授法、学習環境、卒業生の就労状況などについて知見を深めるとともに、多くの貴重な示唆を得ることができました。このような機会を賜り、大変光栄に存じ上げます。

貴社の皆様におかれましては、多忙な業務状況にもかかわらず、スタディーツアーの調整・実施過程において、多大なるご尽力を賜り、心より感謝申し上げます。「日本の教育システム」や「知的障害児に対する教育」、「工業高等学校における教育」、「聴覚障害児に対する教育」、「インクルーシブ教育」等の重要なテーマについて、実地に見聞するとともに、実践家・専門家から学ぶことのできる実り多き機会となりました。

今後、本スタディーツアーの成果をモンゴルにおいて活かして参ります。

また、貴社の実施しておられる「障害児のための教育改善プロジェクト」の日本人専門家の皆様におかれましては、平素よりモンゴルの子どもたちや教員のために懸命に業務に携わっておられる姿に感銘と刺激を受けております。

改めまして、この度は誠に有難うございました。皆様のご健勝とご多幸とを心よりお祈りいたします。

敬具

モンゴル教員研修所
所長　A. Tuya